



I–VIII/2021


Тархаасан: 2021 оны 09 дүгээр сарын 14



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 28.0 хувиар өслөө

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.7 (28.0%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.9 (29.9%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 637.9 (28.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 86.8 (11.2%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 14.9 (16.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 2021 оны 8 дугаар сард 1.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 23.1 (1.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 37.9 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 8 дугаар сард 1.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.1 (3.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 101.0 (14.4%) тэрбум төгрөг, газрын тос олборлолт 15.7 (28.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2021 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр, зэсийн баяжмал, металл агуулгаараа, төмрийн хүдэр, хайлуур жонш, чулуун нүүрс, хүрэн нүүрс болон газрын тосны олборлолт өмнөх оны мөн үеэс 4.5 хувиас 2.1 дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарт самнасан ноолуур, ус, ундаа, жүүс, цемент, катодын зэс, 99%, согтууруулах ундаа, шингэн сүү, шохой, малын мах, нүүрсэн шахмал түлш, металл бэлдэц, янжуур тамхи болон баяжуулсан нүүрс зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.2 хувиас 2.2 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2020		2021*		2021* I-VIII / 2020 I-VIII %
		VIII	I-VIII	VIII	I-VIII	
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Чулуун нүүрс	мян.т	3 227.0	14 950.8	819.8	16 525.7	110.5
Хүрэн нүүрс	мян.т	365.9	3 843.3	456.7	4 440.4	115.5
Газрын тос	мян.баррел	514.8	1 895.3	414.8	3 908.4	2.1 ¹
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.т	98.3	835.3	107.8	873.1	104.5
Цэвэршүүлээгүй алт	кг	2 186.4	12 638.7	2 064.6	12 059.4	95.4
Төмрийн хүдэр	мян.т	836.6	5 646.9	994.1	6 071.9	107.5
Хайлуур жонш	мян.т	10.8	85.1	16.8	93.0	109.3
Боловсруулах аж үйлдвэр						
Малын мах	т	1 155.4	9 592.7	945.9	15 991.8	166.7
Шингэн сүү	мян.л	3 463.8	29 459.7	3 922.9	35 345.0	120.0
Гурил	т	15 880.8	141 337.9	9 863.6	139 454.0	98.7
Цэвэр спирт	мян.л	1 028.4	7 172.4	1 011.9	6 703.1	93.5
Согтууруулах ундаа	мян.л	12 352.2	80 270.8	12 211.4	89 746.4	111.8
Ус, ундаа, жүүс	мян.л	21 126.9	229 224.0	34 082.0	240 586.5	105.0
Янжуур тамхи	мян.блок	346.8	1 171.4	359.9	2 411.2	2.1 ¹
Амны хаалт	мян.ш	526.8	8 701.0	77.9	5 142.3	59.1
Гар ариутгагч	мян.л	21.7	231.5	38.0	224.4	96.9
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	149.7	976.0	56.9	245.8	25.2
Самнасан ноолуур	т	61.2	308.8	42.0	318.7	103.2
Баяжуулсан нүүрс	т	201.4	1 218.8	194.7	2 703.6	2.2 ¹
Нүүрсэн шахмал түлш	мян.т	16.0	251.6	53.3	449.6	178.7
Цемент	т	187.7	805.3	172.6	873.1	108.4
Шохой	т	9 064.9	48 801.9	11 960.0	59 422.0	121.8
Катодын зэс, 99%	т	684.2	6 178.8	867.8	6 710.9	108.6
Металл бэлдэц	т	72.1	11 491.2	3 590.4	23 356.3	2.2 ¹

¹ Дахин их

Харин уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбарт алтны олборлолт 4.6 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт гурил, гар ариутгагч, спирт, амны хаалт болон ноолууран сүлжмэл эдлэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.3-74.8 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 16.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.0 (45.3%) их наяд төгрөгөөр

өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 4.4 (61.9%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, тэрбум төгрөг, салбараар


Салбар	2020		2021*			2021* I-VIII
	VIII	I-VIII	VIII	I-VIII	гадаадад	2020 I-VIII
Нийт дүн	1 931.8	11 116.0	2 071.8	16 148.5	10 290.1	145.3
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 300.0	7 140.6	1 495.1	11 557.5	9 453.7	161.9
Боловсруулах аж үйлдвэр	549.8	3 107.6	484.8	3 622.0	836.4	116.6
Цахилгаан, дулааны эрчим хүч	70.3	778.3	79	862.1	-	110.8
Үйлдвэрлэл, усан хангамж						
Ус хангамж, сувагжилтын систем,						
хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	11.7	89.5	12.9	106.9	-	119.4

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 4.4 (61.9%) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 3.2 (61.9%) их наяд төгрөгөөр, нүүрс олборлолтын салбарынх 826.8 (57.3%) тэрбум төгрөгөөр, газрын тос олборлолтын салбарынх 398.3 (3.1 дахин их) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 70.9 хувийг металлын хүдэр олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 21.1 хувийг нүүрс олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 6.2 хувийг газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 1.8 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн эзэлж, газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар, металлын хүдэр олборлолт 2.3 нэгж хувиар өсч, нүүрс олборлолт 4.2 нэгж хувиар, бусад ашигт малтмал олборлолт 0.7 нэгж хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2021 оны эхний 8 сард 159.5 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГ ДЭХҮҮН, салбараар, сараар, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал:

НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:

Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:

Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

Тооцох аргачлал:

Ласпейсийн биет хэмжээний индексийн томьёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum\left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

Q_t- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q₀- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P₀- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W₀- Жин



Тайлбар:

ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр:

ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гаргах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч Б.Энхболд,

статистикч Г.Цэвэлмаа

Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212